

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ АГЕНТЛАГИЙН ДАРГЫН ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 сарын 18

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Хэрэгжилтийн хувь
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар /	
1	2	3	4	5	6	7
1	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг салбарын удирдлага, аймгийн Засаг даргын өмнө хариуцна.		Тогтоол шийдвэрийн Хэрэгжилтийн хувь	100	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс агентлагт хамааралтай нийтлэг хууль тогтоол шийдвэрийн жагсаалтаар хяналтад авсан 9 заалтыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.	100/90
2	Монгол Улсын Засгийн газрын болон Дундговь аймгийн засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дундговь аймгийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан хариуцсан салбарын зорилт, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.	30.0 сая төгрөг	- Үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлсэн эсэх Тийм-1, үгүй-0  Тухайн жилд зөрчилгүй болсон иргэний тоо	2  8200	“Гэрэгэ” киоск төлбөрийн машиныг нэг цэгийн үйлчилгээний танхимд төрийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн. Эрдэнэдалай, Дэрэн сумдын ИТХурлаар орон нутгийн санхүүжилтээр /тус бүр 5,0 сая төгрөг/ гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулан батлуулж төлбөрийн Гэрэгэ системийг бүрэн нэвтрүүллээ. Сайнцагаан суманд төлбөрийн пос машин УБЕГ-ын санхүүжилтээр нэвтрүүлж үйлчилгээний шат дамжлагыг буурууллаа. Пос машиныг зөөврийн төхөөрөмжийн хамт ашиглаж баг, хурлын танхим, байгууллагуудаар үйлчилгээ явуулахад ашиглаж байна. Бүртгэлийн үйлчилгээний киоск машинаар дамжуулан иргэний бүртгэлийн 12 төрлийн лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах, гадаад паспортын зураг илгээх, оршин суугаа хаягийн шилжилт хөдөлгөөн, цахим иргэний үнэмлэхийн мэдээлэл, тоон гарын үсэг авах зэрэг 5 төрлийн үйлчилгээ мөн 28 төрлийн бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх боломжтой болсон. 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр УБЕГазраар шийдвэрлүүлэн аймгийн ЗДТГ-ын цахим үйлчилгээний хэсэгт байршуулсан. Улсын бүртгэлийн киоск машинд	100



					<p>ПОС суурилуулж үйлчилгээнд орууллаа. Иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн төрөлтийн бүртгэлд овог, эцэг эхийн нэр, бүртгэлийн дугаар зөрүүтэй бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг анхан шатны журнал бүртгэл иргэдийн гар дээр байгаа бичиг баримтад үндэслэн жагсаалтаар иргэний улсын бүртгэлийн газарт 2022 онд хүргүүлэн мэдээллийн санд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан. 2023 онд нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 98, нөхөн бүртгэлд 202, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 2 иргэний холбогдох материалыг хүргүүлэн мэдээллийн сангийн зөрчлийг арилгасан. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 11 сарын 9-ний өдөр ИУБГазраас 884 иргэний бүртгэлийн жагсаалт ирсэн. Уг жагсаалтын дагуу мэдээллийн санд цахимжаагүй иргэдийн хувийн хэргийг цахимжуулах хугацаатай үүрэг даалгаврыг хүлээн авч иргэний улсын бүртгэгч, архивчид 5 хоног ажиллаж хувийн хэрэг цахимжаагүй, дутуу цахимжсан 480 хувийн хэргийн 1440 маягтыг архивын санд цахимжууллаа</p>	
3	<p>ХЗДотоод хэргийн сайдаас Дундговь аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээнд туссан салбарын зорилт арга хэмжээг орон нутагт зохион байгуулж хэрэгжилтийг Засаг даргын өөмнө бүрэн хариуцна.</p>	<p>Тоон гарын үсэг олголтын хувь</p>	38	50	<p>Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19042 иргэн буюу 60.1 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 18 нэгжээр дамжуулан олгохоос гадна Аймгийн Засаг Даргын Тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний Киоск машинаар дамжуулан олгож байна. 2023 онд 7041 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.</p> <p>Тоон гарын үсгийг 16174 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 2869 иргэнд гар утасны gsign апплейкшнаар дамжуулан олголоо. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 жи зөөврийн төхөөрөмжөөр аймгийн төвийн ерөнхий боловсролын 4 сургууль, Сайхановоо, Сайнцагаан, Дэлгэрхангай, Дэрэн, Говь-Угтаал сумд, Буянт багийн төвд зохион байгуулагдсан багийн иргэдийн өдөрлөгт 6 удаа тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан. Номин супер маркет, Мандал худалдааны төв, ХБИргэдийн төв, гэрээр байх ХБИргэн, өндөр настангуудад 4 жи</p>	100



					төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгосон. Мөн Хаан банк, Улсын бүртгэлийн ерөнхий газраас хамтран зохион байгуулсан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд үүнд 6 дугаар сард олгосон тоон гарын үсэг, зохион байгуулсан үйл ажиллагаагаар тус аймаг 3-р байр эзлэн /500,0төг/ мөнгөн шагналаар шагнуулсан.	
4	Байгууллагын үйл ажиллагааг шударга, ил тод, хүндрэл чирэгдэлгүй удирдан чиглүүлж, ажлын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Журмын дагуу төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ХШҮХэлтэст хүргүүлж дүгнэгдсэн. Өгсөн зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гаргаж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.	90
5	Салбарын болон, төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албаны мерит тогтолцоог бэхжүүлж ажиллана.		Эрх зүйч мэргэжлээр төгссөн албан хаагчийн тоо, орон тооны хангалт	100	Дэрэн, Хулд сумын Улсын бүртгэгч нар эрх зүйн боловсрол эзэмшиж төгссөн. Өлзийт, Хулд сумын бүртгэгч нар Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад сууж байна. Албан хаагчдыг чадавхжуулах ёс зүйн болон харилцаа хандлага, байгууллагын соёл, шинэ зууны манлайлал сэдвээр сургалт зохион байгуулж багаар ажиллах чадамжийг дээшлүүлсэн. Мөн аймгийн хэмжээнд Төрийн албаны шалгалтад бэлтгэх онлайн анги ажиллуулж 5 удаагийн элсэлтээр 105 хүүхдийг ерөнхий шалгалтад тэнцүүлсэн. Тэдний 80 хувь нь 15 сум, агентлагуудад ажиллаж хүний нөөцийн хангалт хийгдсэн. Төрийн албан хаагчдын Монгол бичгийн олимпиадад оролцож 5-р байр эзэлсэн. 5 агентлаг, байгууллагад урилгаар ТАХаагчдын манлайллын талаар лекц уншсан. Сум болон аймагт орон тоо бүтэн ажиллаж хүний нөөцийн хангалтыг 100 хувь хийсэн.	100/90
6	Хуулиар олгосон чиг үүрэг, үйл ажиллагааны онцлог, стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нийцүүлэн	5,1 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын сургалтын нэгдсэн хөтөлбөр, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг ханган ажиллах ажлын хүрээнд 2023 онд зохион байгуулах сургалт, нийгмийн	100



	хүний нөөцийн хэрэгжээ шаардлагыг тодорхойлж, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх				баталгааны төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. Сургалт, нийгмийн баталгааны тайланг гаргаж хүргүүлсэн. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт – 100 Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт - 100	
7	Шилэн данс, цахим мэдээллийн ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чанд баримтлан, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллана.	-	Мэдээний хувь	100	Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 1-ний дотор, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтыг тайлагнах (Бүтэн жилээр, хагас жилээр), Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр), Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр), гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг мэдээлэх хуулийн заалтыг мөрдөж дутагдал үүсгэлгүй ажилласан. 1-ээс 11-р сард нийт 127 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан.	100
8	Гадаад зээл, тусламж, ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн үр ашигтай ажлыг хугацаанд нь зохион байгуулна.	20,0 сая	Арга хэмжээний тоо	1	Тус онд Солонгосын Койка төслийн хүрээнд хүний нөөцийг чадавжуулах хөтөлбөр хэрэгжиж хэлтсийн удирдлага Солонгосын шүүхийн байгууллагын дэргэдэх төрийн албан хаагчдын сургалтын төвд 14 хоногийн вакумжуулсан сургалтад сууж сертификатаа амжилттай хамгааллаа. Тус арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг Койка төслийн хүрээнд 100 хувь шийдсэн болно.	100
9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Гэрээ байгуулсан ААНэгжийн тоо	5	2023 онд тус хэлтсийн бичиг хэрэг, шатахуун, бусдаар гүйцэтгүүлэх ажил, жижиг хэрэгсэл худалдан авах зориулалтаар хуульд заасан шалгуурыг хангасан 6 ААНэгтэй гэрээ байгуулан ажиллалаа. Тус онд тендер зарлагдах хөрөнгө оруулалт тусгагдаагүй болно.	100
10	ААНэгж байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг	-	Барагдуулалтын	Барагдуулалтын хувь	Засгийн газрын 11-11, Аймгийн Олон нийттэй харилцах утас 7059106, Хэлтсийн 70592435, УБЕГазар болон	100



	хугацаанд нь шийдвэрлэж хүнд суртал чирэгдэлгүй зохион байгуулж ахиц дэвшил гаргах		хувь 100	100	хэлтсийн удирдлагад цахимаар болон бичгээр, амаар үйл чилгээтэй холбоотой гомдол бүртгэгдээгүй. 2023 онд 40 өргөдөл хүсэлт ирсэн байна. Ажилтнаас 5, Иргэнээс 35 өргөдөл байна. Барагдуулалтын дундаж хугацаа 9 хоног, эерэг байдлаар 100 хувь шийдвэрлэгдсэн. EDOC цахим бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн. СӨГ-ын улирлын мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлж хэлтсийн вэб сайтад тогтмол байршуулсан.	
11	Хүүхэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт ахиц дэвшил гаргана.	3,5 сая	Арга хэмжээний тоо	3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус төвийн дохионы хэлний сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдлаа. Иргэний улсын бүртгэлийн төрөлт, гэрлэлт, эцэг тогтоолтын бүртгэлийн өргөдлийг харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан барелл үсгээр хэвлүүлж өгөхөөр өргөдлийн загварыг гаргуулан авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангах, техник хэрэгслийг сайжруулах зорилгоор сонголын бэрхшээлтэй харилцагчид зориулсан чанга, тод дуутай микрофон, харааны бэрхшээлтэй харилцагчид зориулж мэдээллийн самбар дахь мэдээллийг Arial топ 16 үсгийн фонтоор хэвлэн байршуулсан. 2023 онд 6 ахмадад 4,780.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 12 суманд Гэрлэлтийн булан тохижуулж 3,5 сая төгрөгийн санхүүжилтийг сумдын ЗДТГазраас шийдвэрлүүллээ.	100
12	Албаны болон хувийн ажлаар гадаадад явахдаа аймгийн засаг даргаас зөвшөөрөл авч, удирдамж хөтөлбөрөө батлуулж авч явна.	-	Арга хэмжээний тоо	1	2023 онд хамрагдсан сургалтын хөтөлбөр, удирдамжийг танилцуулан сургалтын үр дүнг тамгын газрын даргад илтгэж цаашид орон нутагт хэрэгжүүлэх боломжтой ажлын саналыг хүргүүлж ажилласан. Тагнуулын байгууллагад холбогдох журамд нийцүүлэн тайланг хүргүүлсэн.	100
13	Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай чанартай гүйцэтгэж байгууллагын соёлыг нэвтрүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулна.	8,0 сая	Арга хэмжээний тоо	4	1. 3000 морин хуур уртын дуучдын наадам тус хэлтсийн 11 албан хаагч хамрагдаж хэлтсээс 1,5 сая төгрөгийн хоол, унааны зардал гарган шийдвэрлэсэн. Нийт албан хаагчийн 39 хувийг хамруулсан байна. 2. Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэлтсийн хамт олон тарьсан модны хашаа орчим, модны ухсан нүхний хогийг цэвэрлэж, 5 удаа усалж	100

				<p>намрын цэнэг усалгаагаар нийт 60 тарьцны арчилгааг хийлээ. Нөхөн тариалалт 30ш хайлаас суулган ургуулж байна. Ургалтын хувь 90. Усалгаа арчилгааны зардалд 250,0 төгрөг зарцуулаад байна.</p> <p>3. Энэ жилдээ эрүүл жиндээ аяны хүрээнд тус хэлтсийн 12 албан хаагч нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэж БЖИлүүдэлгүй болсон.</p> <p>4. Аймгаас зохион байгуулсан 4 удаагийн уралдаан тэмцээнд оролцож УБЕГ-ын спортын наадамд тэргүүн байр эзэлсэн.</p> <p>Авлига, гэр бүл, хүүхэд хамгаалал, жендер, орчны эрсдэл тодорхойлох нийт 6 удаагийн аянд хамт олноороо нэгдэж оролцоог хангасан.</p> <p>“Нээлттэй Дундговь”, Хөрөнгө оруулагчдын чуулганд хамтран ажиллах байгууллагаар сонгогдож арга хэмжээнд оролцож төрийн үйлчилгээний шуурхай байдалд хамтран ажиллах сурталчилгаа, мэдээллийг иргэдэд өгч бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр үзүүлж ажиллалаа.</p> <p>Амьдрах орчны эрсдэлийг бууруулах аяны хүрээнд дэд ажлын хэсгийг ахлан хаягжуулалтын асуудлыг аймгийн хэмжээнд цэгцлэхээр холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгч үндэсний телевиз, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулж иргэдийн хүсэлтээр, программын түвшинд хаягийг цэгцлэх ажлыг хийж эхэллээ.</p> <p>“Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд Дундговь аймагт улсын бүртгэлийн үйлчилгээ, банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг шуурхай авах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, ХХҮГазар, банк санхүүгийн байгууллагууд чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, чирэгдэл үүсгэхгүй байх, иргэдийг цахим орчинд төрийн үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулахад анхан шатанд шийдвэрлэж болох зарим асуудлыг хамтын ажиллагаан дээр шийдвэрлэх, холбогдох дүрэм журамд өөрчлөлт</p>
--	--	--	--	---



					<p>оруулах саналыг дээд шатны байгууллагууддаа хүргүүлэх саналуудыг нэгтгэн салбар бүрээр гаргалаа.</p> <p>Аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс зохион явуулсан монгол бичгийн олимпиадад амжилттай оролцож 5-р байранд орсон. Хүмүүн бичиг сониныг хамт олноороо захиалан уншиж байна. Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19271 иргэн буюу 60.1 хувьд олгоод байна.</p> <p>Тоон гарын үсгийг 18 нэгжээр дамжуулан олгохоос гадна Аймгийн Засаг Даргын Тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний Киоск машинаар дамжуулан олгож байна. 2023 онд 7041 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Тоон гарын үсгийг Иргэний үнэмлэхийн чипэнд 16276, 2995 гар утасны апп-д gsign апплейшнаар дамжуулан олголоо.</p> <p>Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 жи төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлж ХААН банкнаас улсын хэмжээнд зарласан уралдаанд 3-р байр эзэлж 500.0 төгрөгөөр шагнагдсан.</p>	
14	<p>2023 оныг Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, алба хаагчид болон иргэд олон нийтийн эрх зүйн боловсрол мэдлэгийг дээшлүүлж, тус жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	1280,0	Арга хэмжээний тоо	3	<p>Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01 захирамжаар “Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил” болгон зарлаж, уг жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 5 чиглэлээр 38 арга хэмжээг төлөвлөснөөс Улсын бүртгэлийн хэлтэс нь Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 4 дүгээр чиглэлийн 21 дүгээрт заасан Төрийн байгууллагуудтай хамтран “Багш өдөр” үйл ажиллагааг зохион байгуулах, 29 дүгээрт заасан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж үйлчилгээг иргэд, байгууллага, сумдад зохион байгуулах гэсэн заалтуудын хүрээнд 3 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан ажил зохион байгуулж ажиллалаа. Улсын бүртгэлийн байгууллага нь “БҮРТГЭГЧ БАГШ” үйл ажиллагааг БРЕНД болгоод 3 дахь жилдээ Дундговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж байна. “Бүртгэгч багш” үйл ажиллагааны давуу тал - Сурагчид төрөөс насан эцэслэх хүртэлх хүний амьдралын бүхий л харилцааны</p>	100



					<p>талаарх ойлголтыг хөгжилтэй, тоглоомын аргаар мэдэж авдаг. Түүнчлэн 16 насанд хүрээд анхны иргэний үнэмлэх авах, газар өмчлөх, хоршооны гишүүнд элсэх гэх мэт харилцаанд ордгоороо давуу талтай юм.</p> <p>Аймгийн төвийн 2 сургууль, хөдөөгийн 14 сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 9,10.11-р ангийн нийт 903 сурагч, багш, ажилчдад "Бүртгэгч багш" үйл ажиллагааг зохион байгууллаа. Аймгийн прокурорын газартай хамтран ерөнхий боловсролын Мандал, Цэгцбилэг, 1-р сургуулийн 9,10-р ангийн 16 нас хүрч буй хүүхдүүдэд зөрчлийн тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. /116 сурагч/ Өлзийт сумын Буянт багийн төвд Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэх зорилгоор тус сумын Засаг даргын тамгын газартай хамтран 2023 оны 09-р сарын 29-ний өдөр "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ" зохион байгууллаа. 2 залуу хосуудынхаа гэрлэлт батлах ёслолын үйл ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулж, Иргэний улсын бүртгэлийн талаарх ойлголт, зөвлөгөөг 18 иргэнд, тоон гарын үсэг олгох бүртгэлийн үйлчилгээг 21 иргэнд, Гэрлэлтийн 2 бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх ойлголт, зөвлөгөөг 12 иргэнд, газрын анхны бүртгэл, Хуулийн этгээдийн талаарх ойлголт, эцсийн өмчлөгчийн бүртгэлийн мэдээллийг 5 иргэнд хүргэн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.</p>	
15	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	200,0	30	60	<p>Нөхөн тариалалт 30ш хайлаас суулгаж ургуулж байна. Ургалтын хувь 90. Усалгаа арчилгааны зардалд 120,0 төгрөг зарцуулаад байна.</p> <p>Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэлтсийн хамт олон тарьсан модны хашаа орчим, модны ухсан нүхний хогийг цэвэрлэж, 3 удаа усаллаа. Намрын цэнэг усалгааг сайтар хийж хамтын сангаас 150,0 төгрөгийг зарцуулсан.</p>	100
16	ХШҮнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх, И-Монголиа системийг иргэдэд	500,0	Үйлчлүүлсэн иргэдийн	50	<p>2023 онд E-Mongolia цахим системээс гэрлэсний бүртгэлгүй 84 лавлагаа, гэрлэлтийн бүртгэлийн 115, иргэний үнэмлэх дахин захиалсан 61, иргэний</p>	100



	сурталчлах, төрийн үйлчилгээг цахимжуулах		тоо		<p>үнэмлэхийн лавлагаа 930, төрсний гэрчилгээний лавлагаа 300, оршин суугаа хаягийн лавлагаа 750 нийт 2240 иргэн бүртгэлийн лавлагаа мэдээлэл авч үйлчлүүлсэн байна. Нийт лавлагааны 88,3 хувийг иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хаягийн лавлагаа эзэлж байна. Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-mongolia системээр баталгаажуулалт хийж 529, e-business.mn зэр нийт 741, нэрийг хүлээн авч татгалзсан 491, зөвшөөрсөн 139, баталсан 111 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан. Жилийн эцэс буюу 11 дүгээр сарын 15-ны байдлаар 506 албан бичиг явуулсан бөгөөд УБЕГ-т 130, хууль хяналтын байгууллагад 214, аймгуудад 80, бусад байгууллагад 82 албан бичиг тус тус явуулсан байна. Тус хэлтсийн хэмжээнд бүртгэгдсэн 554 албан бичиг ирүүлснээс хариутай 243 албан бичиг байгаа бөгөөд бичгийн барагдуулалт 100%, байна. Цагдаагийн байгууллагаас 99, Авлигатай тэмцэх газраас 31, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 63, Прокуророос 6, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 3, Аймгуудаас хувийн хэрэг ирүүлэх тухай 49, бусад байгууллагаас 109, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 126, Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 14, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газраас 109 албан бичиг тус тус ирүүлснийг e-doc системд бүртгэн хариуг хуулийн хугацаанд нь түргэн шуурхай гарган өгч ажиллалаа. Бичиг хэргийн программыг албан хаагч нэг бүр төгс эзэмшиж цаг хугацаа, цаас хэмнэн түргэн шуурхай ажиллаж байна.</p>	
17	Байгууллагын цахим хуудсыг идэвхжүүлэх, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол оруулж хэвших	-	46	98	<p>www.dundgivi.burtgel.gov.mn хаягийг www.burtgel.gov.mn линкээр холбож мэдээллийг шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>63 шалгуур үзүүлэлтийн дагуу сайтад мэдээлэл бүрэн оруулж хяналт хийсэн. QR код үүсгэн мэдээлэл авах боломж бүрдүүлсэн.</p> <p>Шил ажиллагааны хүрээнд хийсэн өөрийн үнэлгээгээр 95%-тай үнэлсэн</p> <p>2023 оны 1-р сараас 12-р сарын 31 хүртэл 82 мэдээлэл түгээсэн байна.</p>	100



					82 мэдээллийг нийт 3827 хандалт авсан байна. Фейсбүүк групп 2,0 мянган дагагчтай болсон. Фейсбүүк фэйж хуудас 1,5 мянган дагагчтай болж нэмэгдсэн.	
18	ISO стандартыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Стандартын хэрэгжилтийн хувь	100	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний батлагдсан стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2012 онд батлагдсан үйлчилгээний стандартын дагуу албан хаагчдыг үнэлж дүгнэж хэвшсэн.	100/0
19	Удирдах, удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод нээлттэй, авлигагүй шударга, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж хүнд суртлыг арилгана.	200,0	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажилласан. Гүйцэтгэлийн тайланг ХЭЗХэлтэст батлагдсан маягаар хүргүүлж дүгнүүлж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь	100
Дундаж хувь						93.1

Хэрэгжилтийг хянасан:

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга *Соньиа Д* / Ж.Өлзийжаргал /

Хэрэгжилтийг нэгтгэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

..... ажилтай ..... гарын үсэг гарын үсгийн тайлал

